



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар A/51

Төмөрбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс ховор амьтныг хамгаалах зорилгоор хэрэгжүүлсэн биотехникийн арга хэмжээний хүрээнд хийсэн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Энхбаяр- (Засаг даргын орлогч)  
Гишүүдэд Д.Хишигсайхан- (Байгаль орчны мэргэжилтэн )  
Э.Мөнгөнзагас- (Мал эмнэлгийн тархвар зүйч)

2. Ховор амьтныг хамгаалах зорилгоор биотехникийн ажлыг гэрээний дагуу хийсэн эсэхэд үнэлэлт, дүгнэлт гарган чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Нямханд)-д даалгасугай.

ДАРГА

А.МОНХ-ЭРДЭНЭ